

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙД, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА, МОНГОЛ УЛСЫН ИХ
СУРГУУЛИЙН БАГШ, ДОКТОР Ж.НАРАНЦАЦРАЛТ-ЫН НЭРЭМЖИТ
ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ САЛБАРЫН ОЮУТНЫ ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛЫН УДИРДАМЖ

Зохион байгуулагч:

МУИС-ийн Газарзүйн тэнхим,
Наранцацралт сан,
Газар зохион байгуулалт, Геодези, Зураг зүйн ерөнхий газар,
Нийслэлийн Газар Зохион байгуулалтын алба
Монголын Кадастрын холбоо

Дэмжигч байгууллага:

Монголын Газар зохион байгуулагчдын холбоо

Хурлын зорилго:

- Оюутны эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг урамшуулах, цаашид эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг дээшлүүлэх;
- Хичээл сургалтаар болон даалгавраар олж авсан мэдлэгийг нь баталгаажуулах;
- Оюутнуудын илтгэх чадвар, бие даасан бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд оршино.

Хамрах хүрээ:

- Монгол Улсын хэмжээнд Газрын харилцаа, хот төлөвлөлтийн чиглэлээр судалгааны ажил хийж буй бакалаврын түвшний оюутнуудад нээлттэй.

Бүртгэлийн хугацаа:

- Эхлэх: 2026 оны 04 сарын 08-ны өдрийн 09:00 цаг
- Дуусах: 2026 оны 04 сарын 22-ны өдрийн 17:00 цаг

Шалгаруулалт:

Илтгэлийг урьдчилан хүлээн авч, комисс хянан шалгаруулах бөгөөд шалгарсан 10 илтгэлийн хурлаар хэлэлцүүлнэ.

Хурлын материал хүлээх авах:

МУИС-ийн 2-р байрны 138б тоотод хэвлэмэл байдлаар дадлагажигч багш Г.Пэрлиймаа-д хүлээлгэж өгөх. Шалгарсан илтгэлийн зохиогчидтой утсаар холбогдоно.

Хурал зохион байгуулагдах газар, огноо:

- Монгол Улсын Их Сургуулийн хичээлийн 1 дүгээр байрны “Эрдмийн танхим” дугуй заал.
- 2026 оны 04 сарын 28-ны 14:00-18:00 цаг

Илтгэлд тавигдах шаардлага:

1. Илтгэлийг эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл бичих зааврын дагуу боловсруулсан байна. Үүнд:
 - Судалгааны ажлын нэр, Зохиогчийн овог нэр, электрон шуудангийн хаяг
 - Судалгааны ажлын хураангуй
 - Түлхүүр үг: нэр үг, ганц тоон дээр бичигдэнэ.
 - Судалгааны үндэслэл, зорилго, зорилт
 - Сэдвийн судлагдсан байдал, онолын хэсэг
 - Судалгааны арга зүй, аргачлал
 - Судалгааны үр дүн
 - Судалгааны ач холбогдол: онолын болон практикийн
 - Дүгнэлт
 - Ашигласан материалын жагсаалт: Цагаан толгойн үсгийн дарааллаар
2. Илтгэлийг Олон улсын IMRAD стандартаар бичих ба хамтарсан болон ганцаарчилсан илтгэл байж болно.
3. Илтгэлийг шалгаруулах шалгуур үзүүлэлтүүд:
 - Шинэлэг санаа, шийдэл
 - Судалгаа шинжилгээний арга зүйн ашиглалт, боловсруулалт
 - Сэдвийн агуулгад нийцсэн байдал
 - Гаргасан дүгнэлт бодитой эсэх
 - ЭШ-ний илтгэл бичих шаардлагыг хангасан байдал, илтгэх чадвар
 - Илтгэх хугацаа 7-8 минут байх

Илтгэлийг дүгнэх, шалгаруулах:

1. Шалгаруулалт 2 үе шаттайгаар явагдана.
2. Эхний үе шатанд шилдэг илтгэл шалгаруулах ажлын хэсгийн гишүүд илтгэлүүдтэй нэг бүрчлэн танилцаж, уг журмын 2.3-т заасан шаардлагуудын дагуу дүгнэнэ. Ажлын хэсгийн гишүүн бүр дээрх шалгуур үзүүлэлтүүдийн эхний таван үзүүлэлт тус бүрд 1-10 хүртэлх оноо, сүүлийн нэг үзүүлэлтэд 1-5 хүртэлх оноог өгч нийт 55 хүртэлх оноогоор дүгнэнэ. Ажлын хэсгийн гишүүдийн өгсөн онооны нийлбэрээр илтгэлүүдийг цуваагаар байр эзлүүлэн эхний 10 оролцогчийн илтгэлийг 2 дугаар шатанд шалгаруулна.
3. Хоёрдугаар шатанд ажлын хэсэг нь эхний шатнаас шалгарсан 10 оролцогчийн илтгэлийн танилцуулгыг сонсоно. Нэг оролцогчийн илтгэх хугацаа 8 минут байна.
4. Хоёрдугаар шатанд шалгарсан оролцогч бүр танилцуулгаа 'MS Power Point программ дээр бэлтгэж, CD, flash зэрэг өгөгдөл зөөвөрлөх хэрэгсэл дээр хуулж авчирна.

5. Ажлын хэсэг нь оролцогчдын илтгэх ур чадвар, илтгэлийн утга санааг оновчтой зөв, товч тодорхой илэрхийлж буй байдлыг харгалзан тус бүр 1-5 хүртэлх оноогоор дүгнэнэ.
6. Ажлын хэсэг нь оюутнуудыг нэг, хоёрдугаар үе шатанд өгсөн нийт онооны дунджаар байр эзлүүлэн нэг, хоёр, гуравдугаар байр болон ажлын хэсгийн гишүүдийн саналаар 2 тусгай байрыг шалгаруулна.
7. Зохион байгуулагчдаас байр эзэлсэн оролцогчдыг мөнгөн шагналаар урамшуулна.
8. Шалгарсан илтгэлүүдийг ажлын хэсгийн ахлагч уралдааны шалгаруулалтын дүнгийн хамт удирдлагад танилцуулж, илтгэлд дэвшүүлсэн шинэлэг санаа, шийдлийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

Холбоо барих: perliimaa.g@num.edu.mn, 80265081